

ИХ ГҮҮШ Ц.ДАМДИНСҮРЭН АБУГАЙН ОРЧУУЛГЫГ ХЭН “ОЙЛГОМЖТОЙ БОЛГОН САЙЖРУУЛАВ”?

С.Эрдэнэмаам⁷³

Аннотация: В настоящей статье автором выражается возмущение по поводу того, что в последние годы наблюдается резкое ухудшение качества перевода с иностранных языков на монгольский художественной литературы, в том числе и с русского. Более того, на прилавках книжных магазинов стали появляться детские сказки, ранее уже переведенные на монгольский язык, причём переведенные лучшими умами отечественного переводоведения, т.е. нашими классиками, в их так называемом отредактированном и улучшенном варианте, что, на наш взгляд, никоим образом недопустимо как в морально-эстетическом плане, так и в плане угрозы дурного влияния на интеллектуальное развитие подрастающего поколения.

Түлхүүр үг: алтан загас, гучин жил тэнэх, дөчин жил суух, хөрст алтан дэлхий, ойлгомжтой болгон сайжруулах

Саяхан номын дэлгүүрт явж байтал “Зураач Б.Төрмөнх. Алтан загасны үлгэр” гэсэн, бага насны хүүхдэд зориулан хэвлэсэн зурагт ном нүднээ тусав. Гэтэл гадна хавтсан дээр нь алдарт А.С.Пушкины ижил нэрт үлгэрийн өвгөн, загас хоёрын зураг байна. Нээж үзэхэд, хавтасны ард зохиогчийн болон номын нэр, хэвлэлийн газрын тухай тайлбар сэлт бичдэг хэсэгт “А.С.Пушкин. Алтан загасны үлгэр” гэжээ. “Их гүүшийн орчуулсныг л шинээр хэвлэсэн юм байна, зургийг нь Б.Төрмөнх гэдэг хүн зуржээ, харин зохиогчийн нэр байдаг газарт зураач тэр гэж бичдэг нь яаж байгаа юм бол доо” гэсэн бодол төрөөд, жижиг үсгээр жирийтэл бичсэн тайлбарыг уншсан чинь “... Энэхүү номын зураг дүрслэл, текстийн үг хэллэг, найруулга нь бүрэн шинэчлэгдсэн тул эхийг хэвлэлийн газрын зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, ... түгээн тараахыг хориглоно” гэсэн байв. Үүнийг уншаад “ихэд цочиж”, арын хавтасны гадна талд бичсэнийг сонирхон үзвэл “... Монгол хэлнээ академич Ц.Дамдинсүрэн яруу сайхнаар буулгасан байдаг бөгөөд бид энэ удаа зарим нэг үг хэллэгийг ойлгомжтой болгон засварлаж, анх удаа бие даасан зурагт ном болгон уншигч багачууддаа хүргэж байна. Сувдаг шунахай сэтгэл эцэстээ юунд хүргэдгийг өгүүлэх “Алтан загасны үлгэр”-ийг та хүүхдэдээ уншиж өгч, харилцан ярилцаарай. ... бяцхан үрдээ үдэш бүр ... уншиж өгч байгаарай” гэжээ. Гайхах сэтгэл туйлдаа хүрч, “Хэн гуай нь ингэж ойлгомжтой болгон засварласан юм бол, Ц.Дамдинсүрэн гуайгаас илүү сайн орчуулагч төрж дээ” гэж бодоод эхний хуудсыг дахин нээж үзэхэд “дахин орчуулсан”, “засаж сайжруулсан” хүний нэрийг бичээгүй байна, тэр ч атугай редакторын нэр ч алга.

⁷³ МУБИС-ийн профессор, доктор

Яг юуг нь, чухам яаж засч сайжруулсныг даруйхан олж харах хүсэл төрөөд, эхний хуудсыг эргүүлэн уншвал, хүүхэд бүрийн цээжээр мэдэх “Хөрст алтан дэлхийн Хөвөө хязгаар нутагт” гэсэн энгүүн бөгөөд уран яруу тансаг хоёр мөрийг “Хөрст алтан дэлхийн Хязгаар нэгэн нутагт” гээд, “Хөх цэнхэр далайн Эрэг ирмэг газарт” гэдгийг “Хөх цэнхэр далайн Хөвөө зах газарт” болгочихжээ. Ер нь бадаг бүрийг “сайжруулсан” бололтой. “Газрын агуйд хоргодож, Галын элчинд шүтэж, Гучин жил тэнэж, Дөчин жил суужээ” гэсэн амтат сайхан домогт мөрүүдийг “Газар гэрт хоргодож, Гучин гурван жил, Айл болон амьдарч, Аж төрөн суужээ” гэснийг үзээд бухимдах сэтгэл минь ч бас туйлдаа хүрлээ.

Арын хавтасны ард байрлуулсан сурталчилгааны хэсэгтээ энэ номыг хэвлэгч “Сувдаг шунахай сэтгэл эцэстээ юунд хүргэдгийг өгүүлэх “Алтан загасны үлгэр”-ийг та хүүхдэдээ уншиж өгч, харилцан ярилцаарай” гэж бичсэн тухай дээр өгүүлсэн билээ. Чухамхүү сувдаг шунахай сэтгэл эцэстээ юунд хүргэдгийг “засан сайжруулсан” хүмүүс яруу тод харуулаад өгчээ. Уран зохиол, бизнес хоёрыг хольж хутгаж болохгүйг сувдаг шунахай сэтгэлтнүүд ухаараагүй бололтой. Уран зохиол, түүний дотор яруу найраг гэж чухам юуг хэлдэг, зохиолыг яагаад уран гэдэг үгээр тодотгодог тухай анхны мэдэгдэхүүнгүй, уран сайхны мэдрэмжийн үнэр ч үгүй байж, сонгодог зохиолын сонгодог орчуулгыг сувдаг сэтгэлдээ хөтлөгдөн ийнхүү сэглэж болно гэж үү? Ийм зүйлийг “бяцхан үрдээ үдэш бүр уншиж өгөөд” байвал бидний ирээдүй хойч чухам хэн болж хүмүүжих вэ?

“Ровно тридцать лет и три года” гэсэн “олон жил, их удаан” хэмээх утга бүхий хэллэгийг их гүүш “Гучин жил тэнэж, Дөчин жил суужээ” гэж утгыг бүрэн хадгалан сайхан буулгасан байхад, энэ номыг хэвлэгч “Гучин гурван жил” гэж их л “точно” “орчуулжээ”. Ц.Дамдинсүрэн абугай “тридцать лет и три года” гэдэг нь нийлээд “гучин гурав” болно гэдгийг мэдээгүй хэрэг үү? Олон сайхан төгс орчуулга хийсний дээр шинэ үеийн уран сайхны орчуулгын туршлагыг буй болгосон төдийгүй, орчуулгын онолыг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулж, монголын орчуулгын түүхэнд онцгой байрыг нэгэнт эзэлсэн [5] их эрдэмтэн үүнийг мэдэхийн дээдээр мэдэж байсан хэдий ч, “хэлбэрийг өөрчилж болох ч, агуулгыг хөндөж яахин болно” [3] гэсэн өөрийн онолын байр сууриндаа бат зогсож, тухайн хэллэгийн утгад дүйх, монгол үлгэрийн жишгээр ийнхүү “гучин жил тэнэж, дөчин суужээ” хэмээн чадварлаг оноосон хэрэг юм. Дашрамд тэмдэглэхэд, “Гучин гурав” нь оросуудын хувьд зүгээр ч нэг тоо биш, энэ бол Иисус Христ гэгээрлийг олж, түмний нүглийг наманчлан, хүмүүн төрөлхтнийг сайн сайхны замд хөтлөөд, өөрөө цовдлогдсон буюу түүний насалсан нас. Ер нь оросын ард түмэн гурвын тоог эрт дээр үеэс ихэд шүтэж, сайн сайхны бэлгэдэл болгосоор ирсэн түүхтэй, “Бурхан гурвын тоонд дуртай” хэмээн үздэг, энэ бол ид шидийн хүчтэй тоо гэдэг. “Гурван хүү, гурван гүнж, гурван баатар, гурван хүслээ хэл, хүссэн зүйлээ авахын тулд гурван сорилгыг давах” гэх зэргээр эрт үеэс уламжлагдаж ирсэн үлгэр домогт маш олон гардаг шидэт тоо юм. Харин “Тридцать лет и три года” гэдэг нь гурвын тооны бэлгэдэлд улам хүч оруулж, “маш олон, их удаан жил” хэмээх утгыг илэрхийлж буй болохоос биш, түс тас гучин гурав гэж тодорхой яв цав хугацааг илэрхийлсэн хэрэг огтхон ч биш болой.

Орчуулахдаа зохиолын хэлбэрт гар хүрч болно, харин агуулгыг хөндөж яавч болохгүй гэсэн, өнөөгийн орчуулагчдад онолын баримжаа болсоор ирсэн, болсоор байгаа зарчмаа тодорхойлсон түүний өгүүллийг утга зохиолын шүүмж судлаач эрдэмтэн Ц.Магсар өндрөөр үнэлж, “Олег сэцний дуулал” орчуулсан ба тайлбарласан нь” өгүүлэлдээ тэрбээр орчуулж буй зохиолоо унших гэж буй ард түмнийх нь сэтгэл зүйд зохицуулан тохируулах нь чухал болох тухай орчуулгын онолын салбарт өөрийн дэвшүүлсэн үзэл баримтлалаа нотлон харуулсан” хэмээн цохон дурьдсан байдаг билээ [5].

Нөгөөтэйгүүр, их гүүш энэ үлгэрийг одоогийн залуус шиг барьж аваад л, шуудхан шударчихсангүй. Эхэлж орчуулснаа бусдаар шүүлгэж, гадаадын өөр хэлэнд хэрхэн буулгасныг судалж, дүн шинжилгээ хийж байж сая түмэнд толилуулсан гэдэг. Тэрээр энэ тухайгаа орчуулгын онолын хувьд одоо ч үнэ цэнтэй гарын авлага, хэрэглэгдэхүүн болсоор байгаа нэгэн өгүүлэлдээ “Би юу ч нэмж, хасалгүй яг үгчлэн орчуулах гэж оролдов. Тэгээд энэ орчуулгаа монгол хүнд уншиж өгөхөд, миний орчуулга тэдэнд сонин биш байв. Энэ нь надад сургамж боллоо. Би төдий л сайн орчуулсангүй гэдгээ ойлгож, орчуулгаа сайжруулах зорилт тавилаа. Эхлээд би Буриадын Дашнямын Цэдэндамбын орчуулсан “Алтан загасны үлгэр”-ийг анхааралтай уншив. Дараа нь Позднеевын халимагийн тод үсгээр хэвлүүлсэн “Алтан загасны үлгэр”, мөн Сайнбилэгийн Хасарын орчуулж, 1937 онд Элистэд хэвлүүлсэн “Алтан загасны үлгэр”-ийг уншив. Энэ гурван орчуулгаас надад Сайнбилэгийн Хасарынх илүү таашаагдав...” [3] хэмээн бичсэн байдаг.

Алдарт эрдэмтэн, их гүүш Ц.Дамдинсүрэн гуайн аль 1940 онд эх хэлнээ эгээ л монгол үлгэр мэт болгон яруу тансгаар буулгасан энэ сайхан зохиолыг өдий олон жилийн турш монголын хэдэн арван үеийн хүүхэд залуус шимтэн уншиж, бүгдээрээ шахуу цээжээр мэддэг, зарим нь түүний зохиол ч гэж андуурдаг болсон билээ. Үнэхээр л орчуулгын зохиол гэж бодохын аргагүй, яг л монгол үлгэр лүгээ адил болгосон нь тэр эрхмийн гавьяа юм. Энэ олон жил болоход дотоод, гадаадын үе үеийн эрдэмтэн судлаач, утга зохиолын шүүмжлэгчид магтан сайшаасаар ирсэн болохоос биш, ийнхүү “ойлгомжтой болгон засварлаж” байсан удаа байхгүй. Аль 1949 онд Ленинградын улсын их сургуулийн аспирант Н.О.Шаракшинова “Пушкины монгол орчуулгуудын тухай” хэмээх эрдэм шинжилгээний шүүмжлэлт өгүүлэлдээ “Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан “Алтан загасны үлгэр” бол угтаа орчуулга төдий зүйл биш, уран сайхны хувьд дахин боловсруулсан, үлгэрийн агуулгыг бүхэлд нь хадгалсны зэрэгцээ монгол ахуй, монгол байгаль дэлхийг шингээсэн шинэ бүтээл юм. Монгол уншигч эгээ л монгол үлгэр хэмээн хүлээн авахуйц уран сайхнаар найруулж, туйлын гарамгай, чадварлаг сайн буулгажээ” хэмээн өндөр үнэлсэн байдаг [6: 78].

Их гүүш ч орос судлаачийн энэхүү дүгнэлтийг нотлох мэт “Би энэ үлгэрийг монгол хүн монгол үлгэр шигээ хүлээж авахуйцаар орчуулахыг зорьсон... ..Хэдийгээр би Пушкины “Алтан загасны үлгэр”-ийн яг үгчилсэн орчуулга хийгээгүй боловч, уран сайхны хэлний дүрслэгдэхүүний нь хувьд түүнийг огтхон ч бууруулаагүй гэж боддог. Пушкины “Алтан загасны үлгэр”-ийн монгол хөрвүүлэг нь яг үгчилсэн орчуулга биш, харин ямар нэг хэмжээгээр

дууриалган зохиосон бүтээл болсон юм. Ингэхлээр түүнийг үгчилсэн орчуулга биш, “монголчлон” зохиомжилсон орчуулга гэх нь зохимжтой биз. Ингэх нь сайн уу, муу юу гэж асууваас, би сайн ба муу гэж эрс тууштай хариулж чадахгүй. Сайн муу аль аль нь буй байх” хэмээсэн байдаг [4].

Шүүмжлэхийн тулд шүүмжилдэг зарим нэг нь дэндүү урт, нуршуу болгосон, дур мэдэн их зүйл нэмсэн л гэх төдийгөөс хэтэрдэггүй, илүү ойлгомжтой болгож засварлаж байсан түүх бүр ч үгүй билээ. Бид үүгээрээ Ц.Дамдинсүрэн абугайн орчуулгыг төгс төгөлдөр болсон, түүнийг хэн ч шүүмжлэх ёсгүй гэж хэлэх гэсэнгүй, ямар ч сайн орчуулагчийн бүтээлийг түүнээс гарамгай нэг нь засч залруулж болохыг огтхон ч үгүйсгэхгүй. Төгс төгөлдөр орчуулга гэж байдаггүй, төгс төгөлдөрт тэмүүлсэн, түүнд дөхсөн орчуулга л гэж ярьж бичдэгийн учир ч үүнд орших биз. Харин хэлний болон орчуулгын онолын ямар ч үндэслэлгүй, чухамхүү зах зээлийн сэтгэлгээгээр уран зохиолд хандах, халдахыг зөвшөөрч боломгүй. “Ойлгомжтой болгон засварласан” энэ “бүтээл”-ийг уншихад нэрт шог зохиолч агсан Ж.Барамсайн нэгэн өгүүллэг санаанд өөрийн эрхгүй бууж байна. Тэр өгүүллэгт нэгэн албан газрын залуу ажилтан байгууллагынхаа тэргүүний бичээчийн тухай ханын сонинд тавих болж, “Бичгийн цэнхэр машины товгор товгор товчлуур дээр үегүй юм шиг үсчин дэгдэх савхан хуруунууд нь нугын цагаан эрвээхэй нисэн буух адил аа...” хэмээн дүрслэн бичээд, тасгийн даргадаа хянуулахад дарга нь: "Хуруу нь үегүй байх уу даа? Хүний хуруу үетэй шүү дээ... Залуу хүнийг дэврээж хэрэггүй ээ, дарж л байхгүй бол болохгүй" гэх зэргээр шүүмжлээд, ингэж бичих ёстой хэмээн “ойлгомжтой болгон засварлаж” өгснийг нь аваад уншвал “Бичгийн машиныг цохихдоо хуруунууд нь хурдан хөдөлж байдаг” [2: 39] гэсэн байсан тухай гардаг билээ.

Их гүүшийн орчуулгыг ойлгомжтой болгон засварласан нь ч мөн нэг иймэрхүү зүйл болжээ. Тухайлбал, хамгийн эхний мөрийг аваад үзье. “Хөрст алтан дэлхийн Хөвөө хязгаар нутагт” гэснийг “... хязгаар нэгэн нутагт” болгосон нь болхи гэхэд дэндүү болхи аж. Чухамдаа “хөвөө хязгаар” гэсэн тодотгол бол монгол үлгэрт гардаг “газрын мухарт”, “эндээс маш хол нутагт” гэсэн утга бүхий уран дүрслэл билээ. Манай хэвлэгч үүнийг дээрх маягаар сольсон нь дээр өгүүлсэнчлэн бичээчийн хуруу “нугын цагаан эрвээхэй нисэн буухын адил аа”-г “түүний хуруу хурдан хөдөлдөг” болгон зассантай агаар нэгэн бөлгөө.

Уран зохиол бол үгийн урлаг, тийм ч учраас үг бол уран сайхны дүр бүтээх, аливаа зүйлийг уран сайхнаар яруу тансаг илэрхийлэх үндсэн хэрэглүүр юм. Ямар нэгэн утга үүрэг оноож, зориудаар хэрэглэсэн тэр хэрэглүүрийг “засварлан сайжруулах” боломжгүй бөгөөд хэрвээ аливаа нэгэн этгээд тэгж зүрхэлбээс “толгойдоо булуу хурааж буй” хэрэг болно. Бидний хэлэлцэн буй энэхүү “бүтээл”-д “... Гучин жил тэнэж, дөчин жил суужээ” (орос эхэд “Ровно тридцать лет и три года” гэж буй) гэсэн, “маш олон жил” гэсэн утга бүхий яруу дүрслэлийг “Гучин гурван жил ... аж төрөн суужээ” гэсэн нь тухайн утгыг ойлгомжтой болгосон хэрэг огтхон ч биш, харин ч орос хэлний тухайн хэлцийн утгыг гадарладаггүй гэдгээ нийтэд тунхаглан зарласан хэрэг болжээ. Нэг хэлнээс нөгөөд уран зохиол орчуулж байгаа хүн тухайн тэр зохиолд юуны тухай өгүүлж байгаа агуулгыг төдийгүй, энэ агуулгаа

чухам яаж, уран сайхны ямар арга хэрэглүүрээр дамжуулан гаргасныг эх хэлээрээ дүрслэн буулгах учиртай тухай манай нэрт эрдэмтэн, орчуулга судлаач, доктор, профессор А.Шархүү гуай нэгэн өгүүлэлдээ [7: 57] онцлон тэмдэглэсэн байдаг. Гэтэл манай хэвлэгч зохиолын агуулгын талаар, тэр тусмаа түүнийг илэрхийлж буй хэлний уран яруу хэрэглүүрийн тухайд ч ямар ч ойлголтгүй нэгэн бололтой. Тэр ч атугай яруу найраг, шүлэг хэрхэн бүтдэг тухай мэдэхийг ч нэг их хүсдэггүй нь илт. Эс тийм бөгөөс “Өвгөн нь загас барьж, Далайн хөвөө сахина” гэсэн товч бөгөөд тодорхой мөрүүдийг мөн л “сайжруулж”, “Өвгөн нь загас барьж, Өдөржин далайн хөвөө сахина” хэмээн юунд нуршихсан билээ.

Энэ мэт “ойлгомжтой болгон сайжруулсан” “засвар” маш олон байна. Энэ юу болж байна вэ? Уран зохиолд, улмаар өсвөр хойч үеийнхээ оюуны боловсролд яаж хандаад байна вэ? Сайн зохиол бичиж, яруу сайхан орчуулга хийж мөнгө олж болох ч, нийт олноор нэгэнт хүлээн зөвшөөрсөн дэлхийн сонгодог зохиолын шилдэг орчуулгуудыг “ойлгомжтой болгон засварлах” замаар ийнхүү эрэмдэглэж, түүгээрээ хүүхэд багачуудын тархийг угааж, түрийвчээ зузаалах нь зөв үзэгдэл, зүйтэй хандлага мөн үү?

Иймэрхүү сөрөг үзэл хандлагыг таслан зогсоох үүрэг хариуцлага бүхий орчуулгын шүүмж судлал хаахна явна вэ? Монгол улсад орчин үеийн орчуулгын онол, орчуулгын шүүмж судлал 1930-аад оноос эхлэлтэй бөгөөд нэрт дуун хөрвүүлэгч Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нар үндсийг нь тавьсан хэмээн эрдэмтэн судлаачид үздэг. Энэхүү шинэхэн салбар ухааныг Х.Пэрлээ, Ү.Нямдорж, М.Цэдэндорж, Ж.Бадраа, Чой.Лувсанжав, Д.Чойжил, Р.Гүрбазар, Д.Дашдаваа, Ц.Хасбаатар, Г.Аким нарын зэрэг манай нэрт орчуулагч, эрдэмтэн судлаачид залган авч, хөгжүүлэн дэвжээж, залуу хойч үедээ залгамжлуулан өвлүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан [1: 4-5] нь маргаангүй үнэн билээ. Гэтэл сүүлийн жилүүдэд дээрх эрдэмтэн судлаачдынх шиг жинтэй, дорвитой шүүмж туурвих нь эрс ховордож, тал зассан, хий хоосон магтан дэвэргэсэн зүйл нэлээд гарах болов [8: 144-153]. Иймд орчуулгын чанарыг сайжруулъя, ард иргэддээ, нэн ялангуяа хүүхэд залуустаа орчуулгын чанар чансаатай бүтээл барих зорилго эрхэм хэмээн үзэж л байгаа бол энэ чиглэлийн шүүмж судлалд дээр дооргүй анхаарах цаг болжээ. Энэ салбарын мэргэжилтнүүдийг уран бүтээлийн зохих эвлэл, холбоодоос санаачлан захиалах замаар МУИС, МУБИС-ийн сэтгүүл зүйн салбараар тодорхой төлөвлөгөөтэйгөөр бэлтгэж эхлэх шаардлагатай байна. Эс тэгвээс “Сувдаг шунахай сэтгэл эцэстээ юунд хүргэдгийг” нотлон харуулсан энэ мэт номонцор номын дэлгүүрүүдийн лангууг дүүргээд зогсохгүй, өсвөр хойч үеийнхний маань оюун тархийг бохирдуулсаар байх нь ээ.

Ном зүй

1. Адьяа О. Орчуулга: онол, туршлага, сургамж. УБ., 2008, 4-5-р тал.
2. Барамсай Ж. Хэцүү урилга. УБ., 2009. 39-р тал.
3. Дамдинсүрэн Ц. “А.С.Пушкины “Олег сэцний дуулал” орчуулсан ба тайлбарласан нь” эрдэм шинжилгээний өгүүлэл, УБ., 1938.

4. Магсар Ц. Место Пушкина в истоке монгольской поэзии нового времени // [https://nccur.lib.nccu.edu.tw/bitstream/140.119/97061/1/19\(p49-71\).pdf](https://nccur.lib.nccu.edu.tw/bitstream/140.119/97061/1/19(p49-71).pdf)
5. Мөнх-Эрдэнэ Б. Эгнэгт дурсагдах их эрдэмтэн// https://medium.com/@Mogji_haha/%D1%8D%D0%B3%D0% Мэндэлснийх нь 110 жилийн ойд зориулсан эрдэм шинжигээний өгүүлэл.
6. Шаракшинова Н.О. О переводах Пушкина на монгольский язык//Вестник Ленинградского университета, 1949, №6, стр.78.
7. Шархүү А. Орос хэлнээс яруу найраг орчуулж байгаа тухай асуудалд//Туурвил зүй, орчуулга судлалын зарим асуудал. УБ., 2011, 57-р тал.
8. Эрдэнэмаам С. Ойлгох нь орчуулахын амин сүнс//Орчуулга зүй, 2013, №1, 144-153-р тал.